МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

# НЭГДСЭН ТАЙЛАН 2022

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН ӨВЛИЙН XVI НААДАМ 2023




МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН ЗУНЫ VII НААДАМ
БАЯНХОНГОР АЙМАГ 2023.06.19-29

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН ӨВЛИЙН VII НААДАМ 2023



| | |
|---|---|
| Эмхтгэлийг хянасан: | О.Баттулга<br>О.Гэрэл<br>С.Мөнх-Эрдэнэ |
| Мэдээг бэлтгэсэн: | Аймаг, дүүргийн БТСГ, хороодын статистик хариуцсан мэргэжилтнүүд |
| Мэдээг нэгтгэн боловсруулсан: | Б.Ганзориг |
| Газрын зургийн ArcGIS программ дээр ажилласан: | Ч.Цогзолмаа /Япон Улс, Токиогийн Олон улсын их сургуулийн магистрантур/ |
| Холбоо барих хаяг: | ЗГТА-Биеийн тамир, спортын улсын хороо.<br>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо Бага тойруу-55, Спортын төв ордон |

www.sport.gov.mn
https://sport.gov.mn/statistics
info@sport.gov.mn
Утас: 263696
Факс: 325234

© Засгийн Газрын Тохируулагч Агентлаг- Биеийн тамир, Спортын Улсын Хороо

## АГУУЛГА


1. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД ..... 5

2. ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАРИЛГА, ГАДАА ТАЛБАЙ ..... 11

2.1. Спортын барилга байгууламж ..... 11

2.2. Спортын гадаа талбай ..... 12

3. ШИНЭЭР ЦОЛ АВСАН ТАМИРЧИД, ШҮҮГЧИД, ҮНДЭСНИЙ БӨХ, УЯАЧИД, ХАРВААЧИД, ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХЭД ..... 15

3.1 Шинээр цол авсан тамирчид ..... 15

3.2. Цолтой шүүгчид ..... 20

3.3. Үндэсний бөх ..... 21

3.4. Цолтой сурын харваач ..... 23

3.5. Цолтой уяач ..... 26

3.6. Хурдан морь унаач хүүхэд ..... 28

4. БИЕ БЯЛДРЫН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛД ХАМРАГДАГЧИД ..... 30

5. СПОРТЫН ТАМИРЧИД ..... 36

6. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ ..... 39

7. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОГЧИД ..... 45


## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

ЗГТА - Засгийн газрын тохируулагч агентлаг

БТСУХ - Биеийн тамир, спортын улсын хороо

ҮСХ - Үндэсний статистикийн хороо

БТСГ - Биеийн тамир, спортын газар
БТСХ - Биеийн тамир, спортын хорооЗСМ- Захиргааны статистик мэдээ

АСМ - Албаны статистик мэдээ

БТС - Биеийн тамир, спорт

## ӨМНӨХ ҮГ



Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хорооноос салбарын статистик мэдээг 2018 оноос эхлэн 5 дахь жилдээ эмхэтгэн гаргаж байгаа бөгөөд "Биеийн тамир, спортын статистикийн эмхэтгэл-2022"-ыг Та бүхэндээ толилуулж байна.

Энэ удаагийн эмхэтгэлд салбарын статистик мэдээний 5 жилийн динамик үзүүлэлтийг багтаасан онцлогтой бөгөөд салбарын статистик мэдээ сайжруулах чиглэлээр 2017 оноос Статистикийн үндэсний хороотой хамтран авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд ийнхүү салбарын голлох үзүүлэлтээр 5 жилийн өөрчлөлтийг харуулдаг боллоо.

Салбарын статистик мэдээний чанарыг сайжруулах хүрээнд 2024 онд хоёр дахь удаагийн "Биеийн тамир, спортын улсын үзлэг, тооллого"-ыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

"Биеийн тамир, спортын статистикийн эмхэтгэл-2022" тусгагдсан зарим статистик үзүүлэлт цар тахлын дэгдэлтийн өмнөх үзүүлэлтэд хүрсэн байгааг харахад биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагаа 2022 онд бүрэн сэргэж хэвийн хэмжээнд очсоныг харуулж байна.

Энэхүү эмхэтгэл нь Эрхэм таны ажлын хэрэгцээг хангасан, үнэ цэнтэй суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

Биеийн тамир, спортын
улсын хорооны даргыг
үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга

## 1. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД

Монгол Улсад 2022 онд биеийн тамир, спортын нийт 33 байгууллага үйл ажиллагаа явуулж байгааг өмнөх онтой харьцуулахад өөрчлөлтгүй байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотойгоор биеийн тамир, спортын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд буурсан ч тайлант онд үйл ажиллагаа эрчимжиж, сэргэсэн хандлагатай байна.

ГРАФИК 1. Үйл ажиллагаа явуулж буй биеийн тамир, спортын байгууллага, бүсээр




Үйл ажиллагаа явуулж буй биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж буй ажиллагчид 2022 онд улсын хэмжээнд нийт 861 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 187 буюу 27.7%-р өссөн байна. Нийт ажиллагчдын 272 (31.6%) нь нийслэлд, 207 (24.0%) нь Төвийн бүсэд, 171 (19.9%) нь Хангайн бүсэд, 128 (14.9%) нь Баруун бүсэд байгаа бол 83 (9.6%) нь Зүүн бүсэд байна.

Жич: Тайлант оны мэдээ бэлтгэхдээ суманд ажиллаж буй биеийн тамирын арга зүйч нарын тоог оруулсан болно.

ГРАФИК 2. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, бүсээр




Ажиллагчдын тоог аймаг, нийслэлээр авч үзвэл, 272 (69.9%) нь Улаанбаатарт, 56 (11.0%) нь Сэлэнгэ аймагт байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна. Орхон, Өвөрхангай, Дархан-уул, Төв, болон Хөвсгөл аймгуудын ажиллагчдын тоо 2022 онд өмнөх онтой харьцуулахад өөрчлөлтгүй, харин Архангай, Булган, Дорноговь, Сүхбаатар болон Сэлэнгэ аймгуудын ажиллагчдын тоо буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 1. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, аймаг, нийслэл, хүйсээр




2022 он




2021 он




2020 он




2019 он




2018 он

Улсын дунджаар биеийн тамир, спортын 1 ажилтанд биеийн тамир, спортоор зонхилон хичээллэдэг 6 – 64 насны хүн ам 2018, 2019, 2020, 2021 онуудад тус бүр 3676, 3629, 3294, 4131 байсан бол 2022 онд 3988 болсон байна. Харин спортын ажилтан буюу албан тушаалын хувьд мэргэжилтэн, дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйч, эмч нараас бүрдсэн 1 ажилтан тутамд 2018 онд дунджаар 9081, 2019 онд 8384, 2020 онд 7749 , 2021 онд 10274 хүн ногдож байсан бол 2022 онд 9157 хүн ногдож байна.

ХҮСНЭГТ 1. Ажиллагчид, аймаг, нийслэлээр

| Бүс, аймаг, нийслэл | Биеийн тамир, спортын байгууллага | Ажиллагчид - Бүгд | Нэг ажилтанд ногдох хүн ам 2020 | Спортын нэг ажилтанд ногдох хүн ам | Нэг ажилтанд ногдох хүн ам 2021 | Спортын нэг ажилтанд ногдох хүн ам | Нэг ажилтанд ногдох хүн ам 2022 | Спортын нэг ажилтанд ногдох хүн ам |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 33 | 861 | 3294 | 7749 | 4131 | 10274 | 3988 | 9157 |
| Баруун бүс | 5 | 128 | 3379 | 8836 | 3391 | 8732 | 3271 | 6978 |
| Баян-Өлгий | 1 | 27 | 4395 | 9766 | 4493 | 9984 | 4215 | 9484 |
| Говь-Алтай | 1 | 20 | 3091 | 8242 | 2607 | 7077 | 2873 | 7182 |
| Завхан | 1 | 18 | 3644 | 8851 | 3670 | 8913 | 4015 | 12044 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Увс | 1 | 39 | 2838 | 8869 | 2877 | 7990 | 2155 | 3361 |
| Ховд | 1 | 24 | 3099 | 8263 | 3436 | 9449 | 3796 | 10122 |
| Хангайн бүс | 6 | 171 | 3086 | 9257 | 3020 | 8852 | 3538 | 11202 |
| Архангай | 1 | 25 | 3640 | 11440 | 3107 | 8975 | 3747 | 13382 |
| Баянхонгор | 1 | 32 | 2678 | 8332 | 2605 | 8395 | 2773 | 8872 |
| Булган | 1 | 27 | 1854 | 4718 | 1861 | 4737 | 2280 | 7694 |
| Орхон | 1 | 29 | 3065 | 14815 | 3091 | 12806 | 3756 | 12102 |
| Өвөрхангай | 1 | 35 | 2799 | 7536 | 2816 | 7581 | 3296 | 10486 |
| Хөвсгөл | 1 | 23 | 5014 | 12813 | 5077 | 12975 | 5944 | 15190 |
| Төвийн бүс | 7 | 207 | 2121 | 5315 | 2083 | 4783 | 2498 | 6230 |
| Говьсүмбэр | 1 | 24 | 887 | 2154 | 661 | 1383 | 753 | 2009 |
| Дархан-Уул | 1 | 23 | 3768 | 7879 | 3818 | 7983 | 4689 | 9804 |
| Дорноговь | 1 | 39 | 1376 | 4659 | 1394 | 4382 | 1828 | 5484 |
| Дундговь | 1 | 15 | 2607 | 6517 | 2804 | 7851 | 3110 | 7776 |
| Өмнөговь | 1 | 25 | 2590 | 4255 | 2653 | 4359 | 2893 | 4521 |
| Сэлэнгэ | 1 | 56 | 1637 | 4584 | 1616 | 4004 | 1931 | 7207 |
| Төв | 1 | 25 | 3116 | 7790 | 3141 | 6040 | 3710 | 7135 |
| Зүүн бүс | 3 | 83 | 2427 | 7280 | 2461 | 7998 | 2743 | 6152 |
| Дорнод | 1 | 21 | 3868 | 8702 | 4163 | 11796 | 3987 | 10466 |
| Сүхбаатар | 1 | 31 | 1314 | 3848 | 1298 | 3895 | 2095 | 4329 |
| Хэнтий | 1 | 31 | 3463 | 16451 | 3507 | 16661 | 2547 | 5640 |
| Улаанбаатар | 12 | 272 | 4479 | 8305 | 11353 | 22314 | 6123 | 11812 |

Нийт ажиллагчдыг хүйсээр авч үзэхэд улсын хэмжээнд нийт 861 ажиллагчид байгаагийн 362 (42.0%) нь эмэгтэй, 499 (52.0%) нь эрэгтэй ажиллагчид байна.

ГРАФИК 3. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, хүйсээр, аймаг, нийслэлээр




Нийт ажиллагчдыг албан тушаалаар авч үзвэл, нийт ажиллагчдын 297 (34.5%) нь үйлчилгээ, аж ахуйн ажилтан, 160 (18.6%) нь мэргэжилтэн, 139 (16.1%) нь дасгалжуулагч, 102 (11.8%) нь захиргаа болон санхүүгийн ажилтан, 72 (8.4%) нь удирдах албан тушаалын ажиллагчид байна. Харин 91 (10.6%) нь биеийн тамирын арга зүйч, эмч болон бусад албан тушаалын ажиллагчид байна.

ГРАФИК 4. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, албан тушаалаар




Нийт ажиллагчдын албан тушаалыг бүсээр авч үзвэл, Хангайн болон Төвийн бүсүүдэд үйлчилгээ, аж ахуйн ажилтан давамгай байна.

ГРАФИК 5. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, албан тушаалаар, бүсээр




Үйлчилгээ, аж ахуйн ажилтны тоог аймгуудаар авч үзвэл нийт 297 ажилтан байгаагаас хамгийн олон буюу Сэлэнгэ аймагт 31, Өвөрхангай аймагт 18, Дорноговь аймагт 17 тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 2. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, албан тушаалаар, аймаг, нийслэлээр, 2022 он




Дасгалжуулагч болон биеийн тамирын арга зүйч нь энэ салбарт өндөр ач холбогдол бүхий мэргэжил юм. Тус 2 мэргэжлийн статистикийг аймаг, нийслэлээр авч үзвэл, Улаанбаатарт 20 дасгалжуулагч, Увс аймагт 15 арга зүйч байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

ГРАФИК 6. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж буй дасгалжуулагч, аймаг, нийслэлээр




ГРАФИК 7. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж биеийн тамирын арга зүйч, аймаг,



# 2. ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАРИЛГА, ГАДАА ТАЛБАЙ

## 2.1. Спортын барилга байгууламж

Монгол Улсад 2022 онд биеийн тамир, спортын 42 барилга шинээр ашиглалтад орж нийт заалны тоо 1166 болсон байна. Биеийн тамир, спортын улсын анхдугаар тооллогын үеэр нийт 985 заал тоологдсоноос хойш тайлангийн хугацаанд нийт 18.4%-иар нэмэгдсэн байна. Биеийн тамир, спортын барилга нь хэд хэдэн төрлөөс бүрдэх бөгөөд нийт тооны дийлэнх хувийг "спорт заал" эзэлж байгааг доор зургаас харах боломжтой. Хэвийн үйл ажиллагаа явуулж буй 1166 заалны 854 (73.2%) нь "спорт заал" төрөлд хамаарч байна.

ЗУРАГ 3. Спортын барилга, өссөн дүнгээр




ГРАФИК 8. Спортын барилга, дүнд эзлэх хувиар



ЗУРАГ 4. Спорт заал, аймаг, нийслэлээр, 2022




ХҮСНЭГТ 2. Спорт заал, дүүргээр, 2022

| | |
|---|---|
| Улаанбаатар | 337 |
| Багануур | 10 |
| Багахангай | 4 |
| Баянгол | 51 |
| Баянзүрх | 52 |
| Налайх | 13 |
| Сонгинохайрхан | 43 |
| Сүхбаатар | 54 |
| Хан-Уул | 74 |
| Чингэлтэй | 36 |

ГРАФИК 9. Биеийн тамир, спортын барилга, бүсээр




## 2.2. Спортын гадаа талбай

Биеийн тамир, спортын зориулалт бүхий 65 гадаа талбай 2022 онд ашиглалтад орж нийт гадаа талбайн тоо 999 болсон байна. Биеийн тамир, спортын улсын анхдугаар тооллогын үеэр нийт 777 гадаа талбай тоологдсоноос хойш тайлангийн хугацаанд нийт 28.9 хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 5. Спортын гадаа талбай, өссөн дүнгээр




ЗУРАГ 6. Спортын гадаа талбай, аймаг, нийслэлээр, 2022




ХҮСНЭГТ 3. Спортын гадаа талбай, дүүргээр, 2022

| | |
|---|---|
| Улаанбаатар | 202 |
| Багануур | 9 |
| Багахангай | 22 |
| Баянгол | 14 |
| Баянзүрх | 29 |
| Налайх | 28 |
| Сонгинохайрхан | 16 |
| Сүхбаатар | 24 |
| Хан-Уул | 31 |
| Чингэлтэй | 29 |

Шинээр 2022 онд ашиглалтад орсон талбайн 34 (52.3%) нь Улаанбаатарт, 13 (20.0%) нь Төвийн бүсэд бүсэд байршилтай байна.

ГРАФИК 10. Шинээр ашиглалтад орсон биеийн тамир, спортын гадаа талбай, бүсээр



# 3. ШИНЭЭР ЦОЛ АВСАН ТАМИРЧИД, ШҮҮГЧИД, ҮНДЭСНИЙ БӨХ, УЯАЧИД, ХАРВААЧИД, ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХЭД

## 3.1 Шинээр цол авсан тамирчид

Монгол Улсад 2022 онд нийт 3795 тамирчид спортын цол авсан байна. Үүнээс 2742 (72.3%) нь эрэгтэй, 1053 (27.7%) нь эмэгтэй тамирчид байна.

ГРАФИК 11. Шинээр цол авсан тамирчид, хүйсээр




Шинээр цол авсан тамирчдыг бүсээр авч үзвэл нийслэлд 1600 (42.2%), Хангайн бүсэд 958 (25.2%), Төвийн бүсэд 721 (19.0%) нь, Баруун бүсэд 334 (8.8%) нь харин Зүүн бүсэд 182 (4.8%), цолтой тамирчид байна.

ГРАФИК 12. Шинээр цол авсан тамирчид , бүсээр




Цол авсан тамирчдыг аймгаар авч үзвэл Орхон аймагт 491, Дорноговь аймагт 336, Өвөрхангай аймагт 113, Архангай аймагт 109 байгаа нь өндөр үзүүлэлт бүхий аймгууд байна.

ЗУРАГ 6. Шинээр цол авсан тамирчид, аймаг, нийслэлээр









Тамирчдыг цолоор нь авч үзвэл, 1302 (48.4%) нь спортын мастер, 1076 (40.0%) нь спортын дэд мастер, 313 (11.6%) нь олон улсын хэмжээний мастер цолтой тамирчид байна.

ГРАФИК 13. Шинээр цол авсан тамирчид , цолоор



Цолтой тамирчдын дийлэнх хувийг бүрдүүлж буй спортын мастер цолтой тамирчдыг бүсээр харвал энэ онд нийслэл тэргүүлж байна.

ГРАФИК 14. Шинээр цол авсан тамирчид , цолоор, бүсээр




Спортын мастер цолтой тамирчдыг аймаг, нийслэлээр тодруулбал, Орхон аймагт 187, Дорноговь аймагт 129, Архангай аймагт 43, Дорнод аймагт 31, Говьсүмбэр аймагт 30 тамирчид 2022 онд бүртгэгдсэн байна. Харин Орхон аймагт 119, Дорноговь аймагт 49, Өвөрхангай аймагт 39, Архангай аймагт 37, Дархан-Уул аймагт 34 спортын дэд мастер бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 7. Шинээр цол авсан тамирчид, цолоор, аймаг, нийслэлээр






2021 он




2020 он

2019 он



2018 он




## 3.2. Цолтой шүүгчид

Монгол Улсад 2022 онд нийт 164 цолтой шүүгчид бүртгэгдсэнийг цолоор нь харвал 22 буюу 13.4% нь олон улсын харин 142 буюу 86.6% нь улсын цолтой шүүгчид байна. Нийт цолтой шүүгчдийн 62.8%-ийг эрэгтэй шүүгчид эзэлж байна.

ГРАФИК 15. Цолтой шүүгчид, хүйсээр




Шинээр 2022 онд цол авсан шүүгчид нийслэл болон Хангайн бүсэд давамгай байна. Өнгөрсөн онуудад Ковидын халдвар болон хөл хориотой холбоотойгоор биеийн тамир, спортын арга хэмжээ эрс буурч цол зэрэг шинээр гардуулаагүй бол энэ онд салбарын идэвх өндөр байна.

ГРАФИК 16. Цолтой шүүгчид, бүсээр




## 3.3. Үндэсний бөх

Монгол Улсад биеийн тамир спортын улсын анхдугаар тооллогоос хойш 2022 оны байдлаар өссөн дүнгээр улсын цолтой 426, аймгийн цолтой 2060, сумын цолтой 3977 бөхчүүд байна.

ГРАФИК 17. Үндэсний бөх, цол, өссөн дүнгээр




Улсын цолтой бөх энэ онд 23 аар нэмэгдсэнийг аймгаар авч үзвэл Булган аймагт 4, Увс болон Ховд аймгуудад тус бүр 3 нэмэгдэж бусад аймгуудад нэгээс хоёроор нэмж бүртгэгдсэнээр нэгдсэн тооллогоос хойш улсын цолтой нийт бөхчүүдийн тоо 426 болсон байна. Эдгээрийн 121 (28.4%) нь Архангай аймагт бүртгэгдсэн нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

ЗУРАГ 8. Улсын цолтой бөх, аймаг, нийслэлээр, 2022 он




ЗУРАГ 9. Аймгийн цолтой бөх, аймаг, нийслэлээр, 2022




Сумын цолтой бөхчүүд Баянхонгор аймагт 40, Ховд аймагт 32, нийслэлд 48 харин бусад аймгуудад 5-30 бүртгэгдэж нэгдсэн тооллогоос хойш сумын цолтой нийт бөхчүүдийн тоо 3977 болсон байна. Эдгээрээс 451 (11.3%) нь Дорнод аймагт бүртгэгдсэн нь хамгийн өндөр хувийг эзэлжээ.

ЗУРАГ 10. Сумын цолтой бөх, аймаг, нийслэлээр, 2022




## 3.4. Цолтой сурын харваач

Монгол Улсад 2022 оны байдлаар нийт 338 цолтой сурын харваачид бүртгэгдсэнийг бүсээр авч үзвэл, Баруун болон Хангайн бүсэд тус бүр 93 (27.5%), Төвийн бүсэд 82 (24.3%) тус бүр бүртгэгдсэн байна. Харин Улаанбаатарт 2021 онд цолтой сурын харваач бүртгэгдээгүй бол энэ онд 13 шинээр бүртгэгджээ.

ГРАФИК 18. Сурын харваач, бүсээр




Завхан аймагт 32 буюу хамгийн олон сур харваач бүртгэгдсэн бол үүний дараагаар Говь-Алтай аймагт 28, Хөвсгөл аймагт 27, бусад аймагт 5-20 харваач бүртгэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад бүх аймгуудад цолтой сурын харваачид бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 11. Сурын харваач, аймаг, нийслэлээр




2022 он




2021 он




2020 он




2019 он




2018 он

### 3.5. Цолтой уяач

Монгол Улсад цолтой уяачдын тоо 2022 онд 237 бүртгэгдсэнийг бүсээр харвал, Төвийн бүсэд 68 (28.7%) нь, Хангайн бүсэд 60 (25.3%) нь, Баруун болон Зүүн бүсүүдэд тус бүр 55 болон 41 цолтой уяач бүртгэгдсэн байна.

ГРАФИК 19. Цолтой уяач, бүсээр




Өмнөх онтой харьцуулахад цолтой уяачдын тоо 217 уяачаар өссөн байна.

ЗУРАГ 11. Цолтой уяач, аймаг, нийслэлээр






2021 он




2020 он




2019 он

### 3.6. Хурдан морь унаач хүүхэд

Монгол Улсад 2022 оны байдлаар нийт 12371 хурдан морь унаач хүүхэд байгааг бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд 4745 (38.4%), Төвийн бүсэд 3922 (31.7%) байна. Өмнөх онтой харьцуулахад хурдан унаач хүүхдийн тоо энэ онд 10707-оор нэмэгдсэн байна.

ГРАФИК 20. Хурдан морь унаач хүүхэд, бүсээр




Хөвсгөл аймагт хурдан морь унаач 1825 хүүхэд, Дундговь аймагт 1228, Төв аймагт 1018 хүүхэд бүртгэгдсэн нь хамгийн олон хурдан морь унаач хүүхэд бүртгэгдсэн аймгууд байна.

ЗУРАГ 12. Хурдан морь унаач хүүхэд, аймаг, нийслэлээр






2021 он




2020 он




2019 он

## 4. БИЕ БЯЛДРЫН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛД ХАМРАГДАГЧИД

Бие бялдрын түвшин тогтоох сорилд 2022 онд нийт 334316 иргэн хамрагдсан бөгөөд тэдгээрийн 149835 (44.8%) нь эрэгтэй, 184481 (55.2%) нь эмэгтэй байна. Сорилд хамрагдагчдыг өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээр 260489 буюу 3 дахин нэмэгдсэн байна.

Өнгөрсөн онуудад бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагчдын тоо огцом буурсан нь дэлхийн нийтийн хамарсан "Ковид-19" цар тахлын улмаас улс орон даяар "бүх нийтийн өндөржүүлсэн бэлтэн байдал", "бүх нийтийн бэлэн байдал" зарлаж, нийтийг хамарсан арга хэмжээг тодорхой хугацаагаар хориглосон, мөн хорио цээрийн дэглэмийг мөрдөх шаардлагын улмаас олон хүнийг хамруулах боломжгүй болсон.

"Ковид-19" цар тахлын нөхцөл байдал хүндрээгүй орон нутагт биеийн тамир, спортын байгууллага хорио цээрийн дэглэмийг мөрдөн ажиллаж тодорхой түвшинд бие бялдрын түвшин тогтоох сорилд иргэдийн хамруулан ажилласан байна.

Харин энэ оноос эхлэн нөхцөл байдал сэргэж биеийн тамир, спортын арга хэмжээг урьдын адил зохион байгуулж, бие бялдрын түвшин тогтоох сорилд олон нийтийг идэвхтэй хамруулж байна.

ГРАФИК 21. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, хүйсээр




Нийслэл Улаанбаатар болон Зүүн бүсэд 2020 онд сорил авах үйл ажиллагаа зохион байгуулаагүй бол 2021 онд мөн адил Зүүн болон Баруун бүсэд сорил авах үйл ажиллагаа зохион байгуулаагүй бол 2022 онд бүх засаг захиргааны нэгжид сорил авах үйл ажиллагаа зохион байгуулсан байна. Тухайлбал, Улаанбаатар хотод зохион байгуулсан сорилд нийт 153055 (45.8%),Төвийн бүсэд 69454 (20.8%), Хангайн бүсэд 56836 (17.0%), Зүүн бүсэд 32525 (9.7%), Баруун бүсэд 22446 (6.7%) иргэн сорилд хамрагдсан байна.

ГРАФИК 22. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, бүсээр




Сорилд хамрагдсан иргэдийг аймаг, нийслэлээр авч үзвэл, нийслэлд хамгийн их буюу 153055 (45.8%), үүний дараагаар Хөвсгөл аймагт 31476 (9.4%), Дорнод аймагт 17024 (5.1%) байна.

ЗУРАГ 13. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, аймаг, нийслэлээр






2021 он




2020 он




2019 он




Хүйсийн тэнцвэрт байдлыг аймаг, нийслэлээр авч үзвэл, ихэнх аймгийн хувьд ойролцоо тооны эрэгтэй, эмэгтэй хамрагдсан байна. Харин Өмнөговь аймгийн хувьд нийт оролцогчдын 80 хувь нь эмэгтэй байна.

ГРАФИК 23. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, хүйсээр, аймаг, нийслэлээр




Бие бялдрын түвшин тогтоох сорилын үнэлгээг улсын хэмжээнд авч үзвэл, “A” үнэлгээ 23.2%, “B” үнэлгээ 31.6%, “C” үнэлгээ 24.4%, “D” үнэлгээ 14.2% , “F” үнэлгээ 6.6% байна. Өмнөх онтой харьцуулахад үнэлгээний хувь “C”- 2.5, “D”- 5.1, “F”-1.6 функтээр тус бүр буурсан бол, “A”- 5.7, “B”- 3.5 функтээр тус бүр өссөн байна.

ГРАФИК 24. Бие бялдрын түвшин тогтоох сорил, үнэлгээний ангиллаар




Улсын хэмжээнд А" үнэлгээний 48.0%, "В" үнэлгээний 49.9%, "С" үнэлгээний 43.5%, "D" үнэлгээний 40.1%, "F" үнэлгээтэй 39.4%-ийг Улаанбаатар эзэлж байна. Харин Зүүн бүсийн хувьд үнэлгээний дүнгийн бүх ангиллын хамгийн бага хувийг эзэлж байна. Тодруулбал, "А" үнэлгээний 9.5%, "В" үнэлгээний 10.1%, "С" үнэлгээний 8.5%, "D" үнэлгээний 10.2%, "F" үнэлгээтэй 12.6%-ийг эзэлж байгаа нь бусад аймгуудын хамрагдсан иргэдийн тооноос бага байгаатай холбоотой юм.

ГРАФИК 25. Бие бялдрын түвшин тогтоох сорил, үнэлгээний ангиллаар, бүсээр




Бүсийн үнэлгээг задлан харвал, Хангайн бүсийн үнэлгээний дүнгийн 23.2% нь "А", үнэлгээтэй байна.

| 2022 | Нийт хамрагдагчдын улсын дунд эзлэх хувь | Үнэлгээний ангилал, дунд эзлэх хувиар | | | | | Үнэлгээний ангилал - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | B | C | D | F | |
| **Баруун** | 6.7% | 22.9% | 20.3% | 27.5% | 17.4% | 11.8% | **100.0%** |
| **Хангайн** | 17.0% | 23.2% | 33.3% | 26.9% | 12.9% | 3.7% | **100.0%** |
| **Төвийн** | 20.8% | 21.2% | 27.1% | 25.5% | 17.8% | 8.4% | **100.0%** |
| **Зүүн** | 9.7% | 22.7% | 32.6% | 21.3% | 14.9% | 8.6% | **100.0%** |
| **Улаанбаатар** | 45.8% | 24.4% | 34.4% | 23.2% | 12.4% | 5.7% | **100.0%** |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| 2021 | Нийт хамрагдагчдын улсын дунд эзлэх хувь | Үнэлгээний ангилал, дунд эзлэх хувиар | | | | | Үнэлгээний ангилал - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | B | C | D | F | |
| **Баруун** | | | | | | | |
| **Хангайн** | 24.1% | 24.6% | 38.4% | 24.5% | 6.4% | 6.0% | **100.0%** |
| **Төвийн** | 70.5% | 14.4% | 24.4% | 27.8% | 23.9% | 9.5% | **100.0%** |
| **Зүүн** | | | | | | | |
| **Улаанбаатар** | 5.3% | 27.9% | 28.9% | 25.7% | 17.0% | 0.5% | **100.0%** |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| 2020 | Нийт хамрагдагчдын улсын дунд эзлэх хувь | Үнэлгээний ангилал, дунд эзлэх хувиар | | | | | Үнэлгээний ангилал - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | B | C | D | F | |
| **Баруун** | 2.8% | 10.5% | 27.3% | 29.4% | 24.7% | 8.1% | **100.0%** |
| **Хангайн** | 24.8% | 18.8% | 40.5% | 26.2% | 12.5% | 2.0% | **100.0%** |
| **Төвийн** | 72.4% | 15.9% | 29.1% | 25.8% | 22.0% | 7.2% | **100.0%** |
| **Зүүн** | | | | | | | |
| **Улаанбаатар** | | | | | | | |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| | Нийт хамрагдагчдын улсын дунд эзлэх хувь | Үнэлгээний ангилал, дунд эзлэх хувиар | | | | | Үнэлгээний ангилал - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | B | C | D | F | |
| **Баруун** | 11.2% | 16.6% | 29.6% | 24.4% | 19.5% | 9.8% | **100.0%** |
| **Хангайн** | 18.1% | 17.8% | 34.8% | 26.6% | 15.6% | 5.2% | **100.0%** |
| **Төвийн** | 19.1% | 20.4% | 31.5% | 23.8% | 16.6% | 7.7% | **100.0%** |
| **Зүүн** | 4.5% | 21.4% | 33.5% | 26.2% | 13.5% | 5.5% | **100.0%** |
| **Улаанбаатар** | 47.2% | 23.4% | 31.6% | 24.1% | 13.7% | 7.2% | **100.0%** |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| | Улсын дунд эзлэх хувь | Үнэлгээний ангилал, дунд эзлэх хувиар | | | | | Үнэлгээний ангилал - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | B | C | D | F | |
| **Баруун** | 6.2% | 18.2% | 30.8% | 27.3% | 17.6% | 6.1% | **100.0%** |
| **Хангайн** | 37.4% | 17.3% | 31.7% | 27.1% | 18.4% | 5.5% | **100.0%** |
| **Төвийн** | 11.7% | 15.5% | 27.5% | 26.4% | 22.1% | 8.6% | **100.0%** |
| **Зүүн** | 2.9% | 25.3% | 29.4% | 25.8% | 15.6% | 4.0% | **100.0%** |
| **Улаанбаатар** | 41.8% | 16.8% | 32.1% | 26.4% | 16.7% | 8.0% | **100.0%** |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

Бие бялдрын түвшин тогтоох сорилын дүнгээр нийт хамрагдагчдын 78292 (23.4%) нь илүүдэл жинтэй байгаагийн 41646 (53.2%) нь эмэгтэй, 36646 (46.8%) нь эрэгтэй байна.

ГРАФИК 26. Бие бялдрын түвшин тогтоох сорил, үнэлгээний дүн, хүйсээр



## 5. СПОРТЫН ТАМИРЧИД

Монгол Улсад 2022 онд нийт 135877 тамирчин бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулбал 26.4%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд 42941 (31.6%) нь, Төвийн бүсэд 21720 (16.0%) нь, Баруун бүсэд 16909 (12.4%) нь, Зүүн бүсэд 12414 (9.1%) байгаа бол Улаанбаатарт 41893 (30.8%) нь байна.

ГРАФИК 27. Тамирчид, бүсээр




Нийт тамирчдын дийлэнх хувийг буюу 66238 (48.7%) нь спорт тоглоом, 20085 (14.8%) нь үндэсний спорт, 19209 (14.1%) нь халз тулаан, хүчний спорт үлдсэн 30345 (22.3%) нь оюуны спорт, хэмжигдэхүүнтэй, цэрэгжлийн болон пара спортын тамирчид эзэлж байна.

ГРАФИК 28. Тамирчид, спортын төрлөөр




Спортын төрлийг бүсээр авч үзвэл, спорт тоглоомын төрөл бүх бүсэд давамгайлж байна. Тодруулбал, Хангайн бүсэд 19217, Баруун бүсэд 8611, Төвийн бүсэд 6835, Зүүн бүсэд 5222, Улаанбаатарт 26353 тамирчин энэ төрөлд бүртгэгдсэн байна.

ГРАФИК 29. Тамирчид, спортын төрлөөр, бүсээр







Нийт тамирчдын тоог аймаг, нийслэлээр авч үзэхэд Баян-Өлгий, Төв, Хөвсгөл, Орхон болон Улаанбаатар хотод хамгийн олон буюу тамирчинтай бол Говьсүмбэр, Завхан аймгуудад бусад аймгуудтай харьцуулаад цөөн тооны тамирчин бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 13. Тамирчид, аймаг, нийслэлээр






2021 он




2020 он




2019 он




2018 он

## 6. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсад 2022 онд нийт 1147 биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд үүний 543 (47.3%)-ыг нь Төвийн бүсэд, 295 (25.7%)-ыг нь Хангайн бүсэд, 98 (8.4%)-ыг нь Баруун бүсэд, 76 (6.6%)-г нь Зүүн бүсэд зохион байгуулсан байна. 2019 оноос хойш зохион байгуулсан спортын арга хэмжээ даруй буурсан нь "Ковид-19" цар тахал дэгдэж Монгол Улсын засгийн газар, УОК-ын шийдвэрээр удаа дараагийн хөл хорио тогтоосонтой холбоотой бөгөөд 2022 онд 3177 арга хэмжээ зохион байгуулсан байна.

ГРАФИК 30. Биеийн тамир, спортын арга хэмжээ



ГРАФИК 31. Биеийн тамир, спортын арга хэмжээ, бүсээр




Зохион байгуулсан нийт арга хэмжээний 1597 (50.3%) нь аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээ байна.

ГРАФИК 32. Биеийн тамир, спортын арга хэмжээ, чанараар




Улсын чанартай арга хэмжээний 66.6% нь Улаанбаатар хотод, бүсийн чанартай арга хэмжээ энэ онд Хангай, Баруун болон Төвийн бүсүүдэд дийлэнх хувь нь зохион байгуулагдсан байна. Бусад бүсүүдтэй харьцуулахад Хангайн бүсэд биеийн тамир, спортын арга хэмжээг илүүтэйгээр зохион байгуулсан байна.

ГРАФИК 33. Биеийн тамир, спортын арга хэмжээ, , чанараар, бүсээр




ЗУРАГ 13. Биеийн тамир, спортын арга хэмжээ, аймаг, нийслэлээр, 2022




Аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээг Дундговь, Өвөрхангай, Төв, Ховд болон Говьсүмбэр аймгуудад, харин сум, дүүргийн чанартай арга хэмжээг Өвөрхангай, Өмнөговь, Увс, болон нийслэлд хамгийн олон тоогоор зохион байгуулсан байна.

ЗУРАГ 14. Биеийн тамир, спортын арга хэмжээ, чанараар












2022 он







2022 он


Аймаг, нийслэлийн
чанартай арга хэмжээ
0
10 - 39
40 - 99
100 - 169


Сум, дүүргийн
чанартай арга хэмжээ
0
10 - 69
70 - 99
100 - 399
400 - 613

2022 он


Аймаг, нийслэлийн
чанартай арга хэмжээ
19 - 39
40 - 59
60 - 99
100 - 370




2022 он

## 7. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОГЧИД

Зохион байгуулсан спортын арга хэмжээнд нийт 1137271 оролцогч хамрагдсан бөгөөд эдгээрийн 251148 (22.1%) нь Хангайн бүсэд, 204536 (18.0%) нь Төвийн бүсэд, 101256 (8.9%) нь Баруун бүсэд, 24031 (2.1%) нь Зүүн бүсэд, 556300 (48.9%) нь Улаанбаатарт хамрагдсан байна. Нийт оролцогчдын тоог өмнөх онтой харьцуулахад 898588 оролцогчдоор өссөн байна.

ГРАФИК 34. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч



ГРАФИК 35. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, бүсээр




Нийт оролцогчдын 606358 (53.3%) нь сум, дүүргийн, 352092 (31.0%) нь аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээнд оролцсон байна.

ГРАФИК 36. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, арга хэмжээний чанараар




Улсын чанартай арга хэмжээнд оролцогчдын 68.9% нь нийслэлийн, бүсийн чанартай арга хэмжээний 47.5% нь Хангайн бүсийн, аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээний 42.4% нь Төвийн бүсийн, сум, дүүргийн чанартай арга хэмжээнд оролцогчдын 66.4% нь Улаанбаатарын оролцогчид байна.

ГРАФИК 37. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, арга хэмжээний чанараар, бүсээр




| 2022 он | Улсын дүнд эзлэх хувь | Чанар, дүнд эзлэх хувиар | | | | | Чанар - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Олон улсын | Улсын | Бүсийн | Аймаг, нийслэлийн | Сум, дүүргийн | |
| **Баруун** | 8.9% | | 2.7% | 0.1% | 3.9% | 2.2% | **8.9%** |
| **Хангайн** | 22.1% | | 0.3% | 0.3% | 10.4% | 11.0% | **22.1%** |
| **Төвийн** | 18.0% | | 0.7% | 0.2% | 13.1% | 4.0% | **17.9%** |
| **Зүүн** | 2.1% | | 0.1% | 0.1% | 1.2% | 0.7% | **2.1%** |
| **Улаанбаатар** | 48.9% | 2.7% | 8.4% | | 2.3% | 35.4% | **48.9%** |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| 2021 он | Улсын дүнд эзлэх хувь | Чанар, дүнд эзлэх хувиар | | | | | Чанар - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Олон улсын | Улсын | Бүсийн | Аймаг, нийслэлийн | Сум, дүүргийн | |
| **Баруун** | 8.6% | | | 2.5% | 67.5% | 30.0% | **100.0%** |
| **Хангайн** | 27.6% | | 1.0% | 0.6% | 48.3% | 50.1% | **100.0%** |
| **Төвийн** | 35.5% | | 0.4% | 0.3% | 76.7% | 22.5% | **100.0%** |
| **Зүүн** | 8.6% | 0.0% | 5.3% | | 91.1% | 3.6% | **100.0%** |
| **Улаанбаатар** | 19.7% | 0.0% | 0.4% | | 21.5% | 78.1% | **100.0%** |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| 2020 он | Улсын дүнд эзлэх хувь | Чанар, дүнд эзлэх хувиар | | | | | Чанар - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Олон улсын | Улсын | Бүсийн | Аймаг, нийслэлийн | Сум, дүүргийн | |
| **Баруун** | 6.9% | | 5.5% | 2.6% | 69.2% | 22.8% | **100.0%** |
| **Хангайн** | 33.1% | | 1.4% | 2.1% | 35.0% | 61.4% | **100.0%** |
| **Төвийн** | 25.0% | | 1.0% | 3.1% | 81.3% | 14.6% | **100.0%** |
| **Зүүн** | 14.3% | | 0.9% | 1.5% | 97.7% | | **100.0%** |
| **Улаанбаатар** | 20.8% | | 2.2% | | 12.6% | 85.2% | **100.0%** |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| | Улсын дүнд эзлэх хувь | Чанар, дүнд эзлэх хувиар | | | | | Чанар - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Олон улсын | Улсын | Бүсийн | Аймаг, нийслэлийн | Сум, дүүргийн | |
| **Баруун** | 7.7% | 0.1% | 0.6% | 6.3% | 73.4% | 19.5% | **100.0%** |
| **Хангайн** | 37.9% | 0.5% | 1.7% | 1.3% | 21.5% | 75.1% | **100.0%** |
| **Төвийн** | 15.6% | 0.5% | 5.9% | 5.1% | 49.1% | 39.4% | **100.0%** |
| **Зүүн** | 6.2% | 0.5% | 5.3% | 2.7% | 63.5% | 27.9% | **100.0%** |
| **Улаанбаатар** | 32.6% | 12.0% | 0.0% | 0.3% | 3.7% | 84.1% | **100.0%** |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| | Улсын дүнд эзлэх хувь | Чанар, дүнд эзлэх хувиар | | | | | Чанар - Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Олон улсын | Улсын | Бүсийн | Аймаг, нийслэлийн | Сум, дүүргийн | |
| **Баруун** | 10.4% | 0.2% | 5.8% | 6.7% | 74.4% | 12.8% | **100.0%** |
| **Хангайн** | 25.6% | 0.0% | 2.0% | 0.8% | 35.9% | 61.2% | **100.0%** |
| **Төвийн** | 21.4% | 0.5% | 6.4% | 6.2% | 47.6% | 39.3% | **100.0%** |
| **Зүүн** | 3.7% | - | 12.4% | 3.5% | 83.6% | 0.5% | **100.0%** |
| **Улаанбаатар** | 39.0% | 8.5% | 0.2% | 0.0% | 3.4% | 87.8% | **100.0%** |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

Зохион байгуулсан спортын арга хэмжээнд Улаанбаатар, Орхон, Өвөрхангай, Төв, Баянхонгор болон Архангай аймгуудаас хамгийн олон тооны оролцогчид хамрагдсан бол Сүхбаатар, Дорноговь аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад цөөн тооны оролцогчид бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 15. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, аймаг, нийслэлээр









2020 он




2019 он




2018 он

Аймаг, нийслэл чанартай арга хэмжээнд оролцогчдын тоогоор Баянхонгор, Сэлэнгэ, Төв аймгууд, харин сум, дүүргийн чанартай арга хэмжээнд оролцогчдын тоогоор Улаанбаатар болон Өвөрхангай аймгууд тэргүүлж байна.

ЗУРАГ 16. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, чанараар







Аймаг, нийслэлийн арга
хэмжээний хамрагдалт
0


Сум, дүүргийн арга
хэмжээний хамрагдалт
0
100 - 900

2021 он


Аймаг, нийслэлийн чанартай
арга хэмжээнд оролцогчид



2021 он







2021 он


Хөвсгөл
Увс
Баян-Өлгий
Сэлэнгэ
Дархан-Уул
Орхон
Завхан
Булган
Архангай
Ховд
Хэнтий
Дорнод
Улаанбаатар
Төв
Говь-Алтай
Баянхонгор
Өвөрхангай
Говьсүмбэр
Сүхбаатар
Дундговь
Дорноговь
Өмнөговь
Аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээнд оролцогчид
2000 - 4999
5000 - 9999
10000 14999
15000 19999
20000 30000


Хөвсгөл
Увс
Баян-Өлгий
Сэлэнгэ
Дархан-Уул
Орхон
Завхан
Булган
Архангай
Ховд
Хэнтий
Дорнод
Улаанбаатар
Төв
Говь-Алтай
Баянхонгор
Өвөрхангай
Говьсүмбэр
Сүхбаатар
Дундговь
Дорноговь
Өмнөговь
Сум дүүргийн чанартай арга хэмжээнд оролцогчид
0
158 3999
5000 7999
16000 19999
20000 59999
318195

2021 он

# ХАВСРАЛТ

Үндэсний статистикийн хорооны даргын зөвшөөрснөөр БСШУС-ын сайдын 2018 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/646 тоот

А-БТС-1

## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН 2022 ОНЫ МЭДЭЭ

Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн эцсийн мэдээг дараа оны 2-р сарын 15-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахим шуудан болон маягтаар ирүүлнэ.

| Бүс, аймаг, нийслэл | МД | Биеийн тамир, спортын байгууллага | Ажиллагчид-Бүгд | Эмэгтэй | Албан тушаалаар: Удирдах ажилтан | Захиргаа, санхүүгийн ажилтан | Мэргэжилтэн | Дасгалжуулагч | Биеийн тамирын арга зүйч | Эмч | Үйлчилгээ, аж ахуйн ажилтан | Бусад | Хөгжлийн бэрхшээлтэй | Эмэгтэй |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **Бүгд** *мөр1=мөр(2+8+15+23+27)* | 1 | **33** | **861** | **362** | **72** | **102** | **160** | **139** | **61** | **15** | **297** | **15** | **18** | **15** |
| **Баруун бүс** ***мөр2=мөр(3:7)*** | **2** | **5** | **128** | **38** | **9** | **15** | **14** | **19** | **27** | **0** | **41** | **3** | **3** | **2** |
| Баян-Өлгий | 3 | 1 | 27 | 6 | 3 | 4 | 2 | 5 | 5 | 0 | 6 | 2 | 0 | 0 |
| Говь-Алтай | 4 | 1 | 20 | 6 | 1 | 3 | 1 | 2 | 5 | 0 | 8 | 0 | 0 | 0 |
| Завхан | 5 | 1 | 18 | 6 | 1 | 3 | 1 | 4 | 1 | 0 | 7 | 1 | 1 | 0 |
| Увс | 6 | 1 | 39 | 9 | 1 | 3 | 10 | 0 | 15 | 0 | 10 | 0 | 1 | 1 |
| Ховд | 7 | 1 | 24 | 11 | 3 | 2 | 0 | 8 | 1 | 0 | 10 | 0 | 1 | 1 |
| **Хангайн бүс** ***мөр8=мөр(9:14)*** | **8** | **6** | **171** | **76** | **11** | **18** | **21** | **20** | **12** | **1** | **80** | **8** | **4** | **1** |
| Архангай | 9 | 1 | 25 | 7 | 4 | 5 | 2 | 2 | 3 | 0 | 9 | 0 | 1 | 0 |
| Баянхонгор | 10 | 1 | 32 | 19 | 1 | 2 | 2 | 7 | 1 | 0 | 12 | 7 | 1 | 0 |
| Булган | 11 | 1 | 27 | 15 | 2 | 4 | 0 | 3 | 4 | 1 | 12 | 1 | 0 | 0 |
| Орхон | 12 | 1 | 29 | 14 | 1 | 2 | 9 | 0 | 0 | 0 | 17 | 0 | 2 | 1 |
| Өвөрхангай | 13 | 1 | 35 | 12 | 2 | 4 | 8 | 2 | 1 | 0 | 18 | 0 | 0 | 0 |
| Хөвсгөл | 14 | 1 | 23 | 9 | 1 | 1 | 0 | 6 | 3 | 0 | 12 | 0 | 0 | 0 |
